

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/13/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас:261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn

Ахлах аудитор П.Амарсанаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Аудитор Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 7 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | 7 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан | 8 |
| 2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | 9 |
| 2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/ | 10 |
| 2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 11 |
| 2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 13 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 0 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 0 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 0 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 1 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд | 1 |
| 3.4.1 Мөнгөн хөрөнгө | 1 |
| 3.4.2 Авлага | 2 |
| 3.4.3 Урьдчилгаа | 2 |
| 3.4.4 Бараа материал | 3 |
| 3.4.5 Үндсэн хөрөнгө | 3 |
| 3.4.6 Өр төлбөр | 4 |
| 3.4.7 Засгийн газрын хувь оролцоо | 5 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 5 |
| 3.5.1 Төсвийн төлөвлөлт | 5 |
| 3.5.2 Төсвийн гүйцэтгэл | 6 |
| 3.5.3 Нэмэлт төсөв | 6 |
| 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл | 6 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 7 |
| 4.1 Ерөнхий зүйл | 7 |
| 4.2 Материаллаг байдал | 7 |
| 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 7 |
| 4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 8 |
| 4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 8 |
| 4.4 Судалгааны үр дүн | 8 |
| 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн | 9 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 9 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 10 |
| 5.1 Албан шаардлага | 10 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 26 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| НУБГ | Нийслэлийн улсын бүртгэлийн газар |
| САГ | Санхүүгийн аудитын газар |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТӨОХХК | Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| УБХ | Улсын бүртгэлийн хэлтэс |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ДАВААНЯМ
ТАНАА

2026.03.25 № 786
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,247.2 сая төгрөгөөр давж, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоогүйгээс ашигт ажиллагаа буурах, үндсэн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байна;
- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж, хөрөнгө зарцуулж, оны эцэст гүйцэтгэлтэй уялдуулан нөхөж батлуулсан;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 166.2 сая төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг Үндэсний үнэт цаас ХХК-иас худалдан авсан;
- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,595.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн;

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т “Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-т “төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах”, Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн засаглалын кодексийг батлах тухай” 2022 оны 145 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 22 дугаар зүйлийн 22.6-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ”, 22.6.3-т “Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх”, 22.6.6-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах” гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Оршин байх”, “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байдал” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн улсын бүртгэлийн газрыг татан буулгаж, төрийн захиргааны 12, төрийн үйлчилгээний 13, нийт 25 албан хаагчийн асуудлыг шийдвэрлэж, 6,204.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 111.1 сая төгрөгийн бараа материалын тооллогыг хийж, цаашид зарцуулах төсвийн санхүүжилтийг ангилал, зориулалтын дагуу харьяаллын дагуу шилжүүлэн, бүртгэж, санхүүгийн хаалтын тайланг гаргасан байна.

Аудитын гол асуудал

Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн 51.0 хувь эзэмшигч 16,115.2 сая төгрөгийн, 49.0 хувь эзэмшигч 15,483.2 сая төгрөгийн хөрөнгийг тус тус хувь нийлүүлж, нийт 31,598.4 сая төгрөгийн дүрмийн сантайгаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус хуулийн этгээд цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, компанийн засаглалын кодексийг бий болгох, санхүү, эдийн засгийн харилцаанд оролцоход хувь нийлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохгүй байгаа нь хувь эзэмшлийн маргаан үүсэх, ашигт ажиллагаа буурах, үндсэн үйл ажиллагаа доголдох зэрэг сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Бусад асуудал

Улсын бүртгэлийн ерөнхий газар E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системээр иргэний бүртгэлийн чиглэлээр 210162 үйлчилгээ, 17008884 лавлагаа, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 126 үйлчилгээ, 4363082 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 215714 лавлагаа, E-Business системээр 162087 үйлчилгээ, 39363 лавлагаа, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 11 үйлчилгээг, улсын бүртгэлийн үйлчилгээний 106 ширхэг цахим машинаар (Киоск) 178967 үйлчилгээ, 521542 лавлагаа, 70777 төлбөрийн үйлчилгээг тус тус үзүүлжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийн хүрээнд "Зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн болон дахин сонгуулийг хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны А/34 дугаар тушаалаар байгуулж, Сонгуулийн ерөнхий хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолд нийцүүлэн 5 бүлэг бүхий 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилтийг бүрэн ханган ажиллажээ.

Монгол Улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ой тохиож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын бүртгэлийн байгууллагыг төрийн дээд Алтан гадас одонгоор шагнаж нийтэд тунхагласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|---|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 21,389,116.2 | 33,559,097.5 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 462,981.0 | 831,052.5 |
| 3 | АВЛАГА | 1,886,145.3 | 8,724,239.7 |
| 4 | УРЬДЧИЛГАА | - | 5,367.3 |
| 5 | БАРАА МАТЕРИАЛ | 19,039,989.4 | 23,998,438.0 |
| 6 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 90,896,261.8 | 74,949,080.2 |
| 7 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 90,896,261.8 | 74,949,080.2 |
| 8 | Биет хөрөнгө | 77,907,691.1 | 66,315,617.0 |
| 9 | Биет бус хөрөнгө | 12,988,570.7 | 8,633,463.2 |
| 10 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 112,285,378.0 | 108,508,177.7 |
| 11 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 3,363,633.9 | 12,441,502.7 |
| 12 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,363,633.9 | 12,441,502.7 |
| 13 | Өглөг | 3,355,869.7 | 12,427,177.9 |
| 14 | Урьдчилж орсон орлого | 7,764.1 | 14,324.9 |
| 15 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 108,921,744.1 | 96,066,675.0 |
| 16 | Засгийн газрын хувь оролцоо | 108,921,744.1 | 96,066,675.0 |
| 17 | Засгийн газрын оруулсан капитал | 12,235,023.2 | 12,230,703.2 |
| 18 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 16,115,170.0 | 16,119,490.0 |
| 19 | Өмч /хувийн/ /ТӨҮГ/ | 15,483,203.0 | 15,483,203.0 |
| 20 | Хуримтлагдсан үр дүн | 64,577,563.6 | 51,745,349.9 |
| 21 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 510,784.3 | 487,928.9 |
| 22 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 112,285,378.0 | 108,508,177.7 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|--|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 123,816,958.4 | 93,422,352.3 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 15,885,433.9 | 17,989,560.6 |
| 3 | Бусад татвар төлбөр хураамж | 15,885,433.9 | 17,989,560.6 |
| 4 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 12,652,095.6 | 75,432,791.7 |
| 5 | Тусламжийн орлого | - | 65,705,843.8 |
| 6 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 95,279,428.9 | - |
| 7 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 125,823,097.8 | 101,712,015.4 |
| 8 | УРСГАЛ ЗАРДАЛ | 125,823,097.8 | 101,712,015.4 |
| 9 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 115,013,880.8 | 99,578,018.4 |
| 10 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 39,492,663.9 | 45,317,644.1 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,958,538.5 | 5,724,343.4 |
| 12 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,363,447.8 | 1,534,414.3 |
| 13 | Хангамж бараа материалын зардал | 1,501,755.2 | 1,363,118.7 |
| 14 | Нормативт зардал | 1,500.0 | - |
| 15 | Эд хогшил урсгал засварын зардал | 179,937.1 | 165,987.5 |
| 16 | Томилолт зочны зардал | 103,177.7 | 144,286.5 |
| 17 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,923,863.8 | 10,320,028.0 |
| 18 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,488,996.9 | 35,008,196.0 |
| 19 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,809,217.1 | 2,133,997.0 |
| 20 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (2,006,139.5) | (8,289,663.2) |
| 21 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | 139.7 |
| 22 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 8,984,841.7 | 2,173,269.1 |
| 23 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (8,984,841.7) | (2,173,129.3) |
| 24 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | (10,990,981.2) | (10,462,792.5) |

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|--|------------------------|------------------------|
| 1 | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 187,858,543.4 | 131,449,618.1 |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 23,437,376.6 | 7,602,273.7 |
| 3 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 23,437,376.6 | 7,602,273.7 |
| 4 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 23,437,376.6 | 7,602,273.7 |
| 5 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 69,210,431.8 | 123,847,344.4 |
| 6 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 69,210,431.8 | 56,992,613.5 |
| 7 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | - | 66,849,730.9 |
| 8 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 5,000.0 |
| 9 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 95,210,735.0 | - |
| 10 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 179,714,964.4 | 129,954,422.1 |
| 11 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 179,714,964.4 | 129,954,422.1 |
| 12 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 125,352,481.1 | 98,225,257.4 |
| 13 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 41,291,312.9 | 46,419,826.2 |
| 14 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,133,830.2 | 5,891,724.5 |
| 15 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,541,338.2 | 1,690,932.2 |
| 16 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 28,073,924.3 | 14,932,646.7 |
| 17 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 1,500.0 | - |
| 18 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 198,964.7 | 183,442.9 |
| 19 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 88,157.7 | 166,262.4 |
| 20 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,505,526.9 | 24,849,187.9 |
| 21 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 28,517,926.2 | 4,091,234.7 |
| 22 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 54,362,483.3 | 31,729,164.7 |
| 23 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 8,143,579.0 | 1,495,195.9 |
| 24 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 5,326,599.6 | 1,127,264.6 |
| 25 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 5,326,599.6 | 1,127,264.6 |
| 26 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 5,326,599.6 | 1,127,264.6 |
| 27 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (5,326,599.6) | (1,127,264.6) |
| 28 | 1.1.3.1 Бусад эх үүсвэр | - | 139.7 |
| 29 | 1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 2,976,879.7 | - |
| 30 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (2,976,879.7) | 139.7 |
| 31 | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (159,900.4) | 368,071.1 |
| 32 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 622,881.8 | 462,981.4 |
| 33 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 462,981.4 | 831,052.5 |

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө / өмч |
|----|---|--|-----------------------|--------------------------|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 92,016,846.4 | | 92,016,846.4 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (3,726,014.2) | | (3,726,014.2) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 88,290,832.3 | | 88,290,832.3 |
| 4 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 31,621,893.0 | | 31,621,893.0 |
| 5 | Тайлант үеийн үр дүн | (10,990,981.2) | | (10,990,981.2) |
| 6 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 108,921,744.1 | | 108,921,744.1 |
| 8 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (2,369,421.2) | | (2,369,421.2) |
| 9 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 106,552,322.9 | | 106,552,322.9 |
| 10 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (22,855.4) | | (22,855.4) |
| 11 | Тайлант үеийн үр дүн | (10,462,792.5) | | (10,462,792.5) |
| 12 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 96,066,675.0 | | 96,066,675.0 |

2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|--------------------------|--------------------------|---------------------------|--------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 69,662,748,900.00 | 63,178,318,782.79 | (6,484,430,117.21) | 90.7 |
| 12 | Татварын бус орлого | 69,662,748,900.00 | 63,178,318,782.79 | (6,484,430,117.21) | 90.7 |
| 122 | Тусламжийн орлого | 69,662,748,900.00 | 63,178,318,782.79 | (6,484,430,117.21) | 90.7 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 69,662,748,900.00 | 63,178,318,782.79 | (6,484,430,117.21) | 90.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 69,662,748,900.00 | 63,178,318,782.79 | (6,484,430,117.21) | 90.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 69,662,748,900.00 | 63,178,318,782.79 | (6,484,430,117.21) | 90.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 68,441,366,100.00 | 62,305,907,812.79 | (6,135,458,287.21) | 91.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 44,864,137,700.00 | 43,333,797,357.32 | (1,530,340,342.68) | 96.6 |
| 210101 | Үндсэн цалин | 26,659,265,500.00 | 23,705,664,288.38 | (2,953,601,211.62) | 88.9 |
| 210102 | Нэмэгдэл | 10,152,369,700.00 | 10,207,014,525.41 | 54,644,825.41 | 100.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,109,044,000.00 | 7,188,233,756.33 | 1,079,189,756.33 | 117.7 |
| 210104 | Урамшуулал | 1,943,458,500.00 | 2,218,563,264.20 | 275,104,764.20 | 114.2 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 14,321,523.00 | 14,321,523.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,913,727,800.00 | 5,620,207,109.22 | (293,520,690.78) | 95.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,420,570,200.00 | 4,180,511,411.87 | (240,058,788.13) | 94.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 373,681,300.00 | 361,653,807.40 | (12,027,492.60) | 96.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 187,295,900.00 | 182,948,881.65 | (4,347,018.35) | 97.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 186,641,900.00 | 179,537,066.68 | (7,104,833.32) | 96.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 745,538,500.00 | 715,555,941.62 | (29,982,558.38) | 96.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,733,410,100.00 | 1,553,515,558.96 | (179,894,541.04) | 89.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 425,311,400.00 | 367,985,729.71 | (57,325,670.29) | 86.5 |
| 210302 | Түлш, халаалт | 964,749,200.00 | 881,508,632.17 | (83,240,567.83) | 91.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 105,298,700.00 | 70,926,297.08 | (34,372,402.92) | 67.4 |
| 210304 | Байрны түрээс | 238,050,800.00 | 233,094,900.00 | (4,955,900.00) | 97.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,279,822,700.00 | 985,649,061.63 | (294,173,638.37) | 77.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 802,250,100.00 | 542,091,732.00 | (260,158,368.00) | 67.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 93,049,700.00 | 89,150,010.00 | (3,899,690.00) | 95.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 226,265,000.00 | 173,667,079.63 | (52,597,920.37) | 76.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 13,032,100.00 | 7,693,340.00 | (5,338,760.00) | 59.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 145,225,800.00 | 173,046,900.00 | 27,821,100.00 | 119.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 180,873,100.00 | 171,353,391.00 | (9,519,709.00) | 94.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 59,810,000.00 | 80,327,130.00 | 20,517,130.00 | 134.3 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 17,093,400.00 | 7,709,170.00 | (9,384,230.00) | 45.1 |
| 210604 | Урсгал засвар | 103,969,700.00 | 83,317,091.00 | (20,652,609.00) | 80.1 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 136,291,500.00 | 136,291,500.00 | - | 100.0 |
| 210701 | Гадаад албан томилолт | 39,000,000.00 | 39,000,000.00 | - | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 97,291,500.00 | 97,291,500.00 | - | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,246,598,400.00 | 6,438,086,883.00 | (1,808,511,517.00) | 78.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,514,000,600.00 | 3,782,755,079.00 | (1,731,245,521.00) | 68.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 12,363,100.00 | 6,346,800.00 | (6,016,300.00) | 51.3 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 24,362,300.00 | 143,100.00 | (24,219,200.00) | 0.6 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 3,881,500.00 | 1,308,135.00 | (2,573,365.00) | 33.7 |

| | | | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|---------------------------|--------------|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 809,800.00 | 140,000.00 | (669,800.00) | 17.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,473,310,800.00 | 1,442,429,016.00 | (30,881,784.00) | 97.9 |
| 210807 | Газрын төлбөр | 13,484,700.00 | 579,153.00 | (12,905,547.00) | 4.3 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,204,385,600.00 | 1,204,385,600.00 | - | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,086,504,800.00 | 4,067,006,951.66 | (2,019,497,848.34) | 66.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,970,680,000.00 | 3,970,679,856.66 | (2,000,000,143.34) | 66.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 115,824,800.00 | 96,327,095.00 | (19,497,705.00) | 83.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,221,382,800.00 | 872,410,970.00 | (348,971,830.00) | 71.4 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,221,382,800.00 | 872,410,970.00 | (348,971,830.00) | 71.4 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 685,751,200.00 | 541,617,242.52 | (144,133,957.48) | 79.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 130,864,900.00 | 111,547,227.48 | (19,317,672.52) | 85.2 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 404,766,700.00 | 219,246,500.00 | (185,520,200.00) | 54.2 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 19,400,227.72 | 19,400,227.72 | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 19,400,227.72 | 19,400,227.72 | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 2549 | 2489 | (60) | 97.6 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 23 | 23 | 0 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 23 | 23 | 0 | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 1247 | 1263 | 16 | 101.3 |
| 620001 | Удирдах ажилтан | 49 | 49 | 0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 1033 | 1049 | 16 | 101.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 165 | 162 | (3) | 98.2 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | 3 | 3 | - |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 1247 | 1171 | (76) | 93.9 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1082 | 1079 | (3) | 99.7 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 9 | 19 | 10 | 211.1 |
| 650010 | Гэрээт ажилтан | 0 | 3 | 3 | - |
| 650014 | Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ) | 156 | 70 | (86) | 44.9 |
| 66 | НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ | 32 | 32 | - | 100.0 |
| 660001 | Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 32 | 32 | - | 100.0 |

2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлант он |
|--------------|---|---------------------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 3,002,910,979.79 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,002,910,979.79 |
| 122 | Тусламжийн орлого | 3,002,910,979.79 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 3,002,910,979.79 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,002,910,979.79 |
| 350013 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 143,700,163.00 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 120,247,500.00 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,738,963,316.79 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,927,924,764.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,927,924,764.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,917,674,764.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,457,415,892.98 |
| 210101 | Үндсэн цалин | 98,893,603.16 |
| 210102 | Нэмэгдэл | 1,204,352,634.84 |
| 210104 | Урамшуулал | 119,826,489.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 34,343,165.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 179,603,671.20 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 134,343,906.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,393,787.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,727,346.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,600,935.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,537,695.80 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,655,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,385,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,412,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 953,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,904,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 104,851,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 94,950,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,901,400.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,500,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,880,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,235,270.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 445,430.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16,200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 124,767,950.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 114,717,950.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,050,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,250,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 10,250,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,250,000.00 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 1,074,986,215.61 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (1,074,986,215.61) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (1,074,986,215.61) |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын бүртгэлийн ерөнхий газрын эрхэм зорилго нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд орших бөгөөд Монгол Улсын төр, засгаас улсын бүртгэлийн чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд, олон нийтэд чанартай, шуурхай хүргэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус газар хуульд заасны дагуу дараах чиг, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах;
- Бүх шатны бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, хадгалах, хамгаалалтын найдвартай байдлыг хангах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллах;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, тэдгээрийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх;
- Салбарын хэмжээний мэргэжлийн боловсон хүчний чадавх, техник технологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;
- Улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах;
- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг нэгтгэх, мэдээлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, үйл ажиллагаанд хэрэглэх баримт бичгийн загвар, маягт, холбогдох заавар, журмыг хуульд заасны дагуу баталж мөрдүүлэх;
- Улсын бүртгэлийн аргачлал, арга зүйг олон улсын ангилал, стандартын жишигт нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр гаргаж мөрдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал: төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйн улмаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдмэл, стандартчилагдсан хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/180 дугаар тушаалаар салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан;

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тухай бүр зөвлөмж өгч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны А/904 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан, шинэчлэхээр Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран салбарын баримт бичгийг боловсруулж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 831.1 сая төгрөг болж, өмнөх оноос 368.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
төгрөгөөр/

/сая

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Төрийн сангийн харилцах | 362.6 | - | (362.6) |
| Арилжааны банк дахь харилцах | 100.3 | 830.2 | 729.9 |
| Арилжааны банк дахь харилцах | - | 0.8 | 0.8 |
| МӨНГӨН ХӨРӨНГӨ | 463.0 | 831.1 | 368.1 |

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 831.1 сая төгрөгийн үлдэгдэлд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн гадаад валют болон төгрөгийн харилцах дансны 815.8 сая төгрөг, арилжааны банк дахь харилцах дансны 15.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- УБЕГ-ын /төв аппарат/ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 166.2 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, анхан шатны баримтгүй 8.3 сая төгрөгийг шилжүүлсэн;
- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн анхан шатны баримтгүй 98.6 сая төгрөг шилжүүлсэн, цалингийн зардлыг 49.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн, захиалагчийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй 9.0 сая төгрөгийн НБББББ хийлгэсэн;

- Ховд аймгийн УБХ 1.3 сая төгрөгийг зардлын ангилал зөрүүлэн зарцуулсан;
- Хэнтий аймгийн УБХ архивын улсын үзлэг нэрээр 16.9 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон;
- Орхон аймгийн УБХ орон нутгийн нэмэгдэлд олгосон 4.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, Засаг даргын захирамжийг үндэслэн 1.5 сая төгрөгийг илүү олгосон, жолоочийн тооцооны хуудсыг хянаж, нэгтгэн тооцоогүй 1.2 сая төгрөгийг зардалд тусгасан;
- Архангай аймгийн УБХ албан хаагчдад олгосон цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 4.8 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж тайлагнаагүй;
- Сүхбаатар аймгийн УБХ орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар тооцож, 4.5 сая төгрөгийг илүү олгосон;
- Дундговь УБХ мөнгөн шагналыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 3.3 сая төгрөгийг олгосон, өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд 7.9 сая төгрөгийн урамшуулал олгосон;
- Дархан-Уул УБХ сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчид 1.6 сая төгрөгийн балансын урамшуулал олгосон;

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 8,724.2 сая төгрөг болж, өмнөх оноос 6,838.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 14.0 | 7.6 | (6.4) |
| Татаас, санхүүжилтийн авлага | 1,062.7 | 1,159.7 | 97.0 |
| Дансны авлага /ТӨҮГ/ | - | 3,430.7 | 3,430.7 |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 720.6 | 359.7 | (360.9) |
| Байгууллагаас авах авлага | 86.7 | 3,766.1 | 3,679.4 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 2.2 | 0.5 | (1.7) |
| АВЛАГА | 1,886.1 | 8,724.2 | 6,838.1 |

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 8,724.2 сая төгрөгийн үлдэгдэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Сангийн яамнаас авах татаас, санхүүжилтийн авлага 1,159.7 сая төгрөг, Бүгд найрамдах Унгар улсын Унгарын мөнгөн тэмдэгт хэвлэл хувьцаат компаниас авах авлага 3,760.0 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 0.5 сая төгрөг, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн харилцагч байгууллагуудаас авах нийт 3,430.6 сая төгрөг, НДШ-ийн авлага болон бусад авлага 373.4 сая төгрөгийн авлагууд тус тус бүртгэлтэй байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 5.4 сая төгрөг болж, өмнөх оноос өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-----------------------------------|----------------|-----------------|------------------------|
| УРЬДЧИЛГАА | - | 5.4 | 5.4 |
| Урьдчилгаа тооцоо | - | 5.4 | 5.4 |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | - | 5.4 | 5.4 |

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны 5.4 сая төгрөгийн үлдэгдэлд үйлдвэрийн зориулалттай хутга ирлүүлсний төлбөрийн үлдэгдэл байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 23,998.4 сая төгрөг болж, өмнөх оноос 4,958.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-----------------------------|-----------------|-----------------|------------------------|
| Түүхий эд материал | 10,064.9 | 19,439.8 | 9,375.0 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 6,559.9 | 2,290.9 | (4,269.0) |
| Хангамжийн материал | 2,381.1 | 2,228.8 | (152.4) |
| Бичиг хэргийн материал | 144.1 | 118.7 | (25.3) |
| Аж ахуйн материал | 1,548.7 | 1,457.1 | (91.5) |
| Сэлбэг хэрэгсэл | 470.4 | 453.8 | (16.6) |
| Түлш, шатах тослох материал | 14.0 | 17.1 | 3.1 |
| Барилгын засварын материал | 0.2 | - | (0.2) |
| Хүнсний материал | 6.2 | 1.1 | (5.2) |
| Бусад хангамжийн материал | 197.5 | 180.9 | (16.6) |
| Мал амьтад | 34.1 | 38.9 | 4.8 |
| БАРАА МАТЕРИАЛ | 19,040.0 | 23,998.4 | 4,958.4 |

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 23,998.4 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 60,059.9 сая төгрөг, Нийслэлийн улсын бүртгэлийн газраас шилжиж ирсэн 111.1 сая төгрөг, малын нас дэвшилт 15.4 сая төгрөг, гадаад паспортын бэлдэц 21,011.8 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 714.4 сая төгрөг нийт 81,912.6 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, үйл ажиллагаанд зарцуулсан 75,984.1 сая төгрөг, данс хооронд шилжүүлсэн 798.6 сая төгрөг, акталж данс бүртгэлээс хассан 12.1 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр 111.1 сая төгрөг, бусад 48.4 сая төгрөг, нийт 76,954.2 сая төгрөгийн бараа материал хасагдсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл өсөхөд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн тусгай зориулалтын материал буюу үнэт цаасны үлдэгдэл голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- ТҮЦХ ТӨОХХК чанаргүй түүхий эд худалдан авснаас 78.2 сая төгрөгийн хорогдол үүсгэсэн, өмнө оны 1,351.1 сая төгрөгийн гологдол үүсгэсэн;
- УБЕГ-ын /төв аппарат/ худалдан авах ажиллагааны 75.8 сая төгрөгийн гэрээг он дамжуулан хийж, гэрээ дүгнээгүй, гүйцэтгэлийг үнэлээгүй;
- Булган УБХ шатахууны зарцуулалтын тайланг нярвын тайлантай тулган баталгаажуулаагүй 2.3 сая төгрөгийг зарцуулсан.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 74,949.1 сая төгрөг болж, өмнөх оноос 15,947.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|--------------------------------|-----------------|-----------------|------------------------|----------------|
| Барилга, байгууламж, орон сууц | 30,644.0 | 29,833.2 | (810.8) | (2.6) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 788.9 | 691.4 | (97.5) | (12.4) |
| Машин тоног төхөөрөмж | 44,882.5 | 34,224.7 | (10,657.8) | (23.7) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,531.6 | 1,521.9 | (9.7) | (0.6) |
| Бусад үндсэн хөрөнгө | 60.7 | 44.4 | (16.3) | (26.9) |
| Биет бус хөрөнгө | 12,988.6 | 8,633.5 | (4,355.1) | (37.1) |
| Програм хангамж | 12,463.5 | 8,120.0 | (4,343.5) | (34.8) |
| Бусад биет бус хөрөнгө | 525.1 | 513.5 | (11.6) | (2.2) |
| НИЙТ ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 90,896.3 | 74,949.1 | (15,947.2) | (103.3) |

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 74,949.1 сая төгрөг болж буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,162.0 сая төгрөг, хандив тусламжаар авсан 176.9 сая төгрөг;
- ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 255, 318, 418, 816 дугаар тогтоолоор 7,443.7 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэх тогтоох тухай” 816 дугаар тогтоолоор дотооддоо шилжүүлсэн 2,245.9 сая төгрөг, 40.6 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээ хийж нэмэгдсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 260, 338 дугаар тогтоолоор акталж, данснаас хассан 5,896.6 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 258, 333, 108 дугаар тогтоолоор шилжүүлсэн 2,246.0 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн бүртгэсэн 6,204.1 сая төгрөг, бусад 3,671.7 дахин үнэлгээгээр 81.3 сая төгрөг, худалдсан 117.9 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус буурсан байна.

Программ хангамж дансанд 18,193.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, 10,073.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 8,120.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 55 нэр төрлийн программ бүртгэлтэй байна. Тайлант онд урсгал зардлаас программын төлбөр, лицензийн төлбөрт 557.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сэлэнгэ УБХ ашиглагдаж байгаа 172.8 сая төгрөгийн 80 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, хөрөнгийн элэгдлийг 7.1 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон;
- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлахгүйгээр 36.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, санхүүгийн программын эх код 49.0 хувийн хувьцаа эзэмшигч компанийн нэр дээр байгаа нь төсвийн үйл ажиллагааны хараат байдалд орж, хөгжүүлэлт хийх боломжгүй байна, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, 23.2 сая төгрөгийн шатахууныг худалдан авсан.
- УБЕГ-ын /төв аппарат/ лицензийн төлбөр 19.2 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал дансаар дамжуулан тохируулах бичилт хийж, зардалд хуваарилаагүй;
- Ховд УБХ байгууллагын эзэмшлийн 13.5 сая төгрөгийн 3000 мкв газрыг данс бүртгэлд бүртгээгүй;
- Баянхонгор УБХ биет бус хөрөнгөнд бүртгэлтэй газар үндсэн хөрөнгийн бүртгэлд 572 мкв, газар эзэмших гэрчилгээ болон цахим санд 1762 мкв буюу 1190 мкв -аар зөрүүтэй байна;
- Сүхбаатар УБХ дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй;

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 12,441.5 сая төгрөг болж, өмнөх оноос 9,077.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Богино хугацаат өр төлбөр | 3,011.5 | 7,056.0 | 4,044.5 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 100.6 | 470.6 | 370.0 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,727.3 | 6,585.4 | 3,858.1 |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 183.6 | - | (183.6) |
| Бусад өглөг | 344.3 | 5,371.1 | 5,026.8 |
| Байгууллагад төлөх өглөг | 12.7 | 5,355.4 | 5,342.7 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 0.8 | 10.4 | 9.5 |
| Татварын өглөг /ТӨҮГ/ | 330.8 | 3.8 | (327.0) |
| НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | - | 1.5 | 1.5 |
| Урьдчилж орсон орлого | 7.8 | 14.3 | 6.6 |
| Өглөг | 3,363.6 | 12,441.5 | 9,077.9 |

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 12,441.5 сая төгрөг болж өсөхөд Улсын бүртгэлийн ерөнхий газар нь Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-д өгөх гадаад паспортын бэлдэц болон бичилтийн төлбөрт 3,358.6 сая төгрөг, Смарт Карт ХХК-д өгөх иргэний үнэмлэхийн бэлдцийн төлбөр 1,613.5 сая төгрөг, Сүхбаатар дүүргийн татвар, нийгмийн даатгалын хэлтэст төлөх 425.5 сая төгрөг, Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК харилцагч байгууллагуудад өгөх 6,581.1 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл голлох нөлөө үзүүлсэн

бөгөөд хэмнэлтийн горимтой холбоотой Сангийн яамнаас санхүүжилт олгоогүйтэй холбоотой өр төлбөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- ТҮЦХ ТӨОХХК харилцагч байгууллагуудтай хийсэн 429.2 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй;
- Төв УБХ шуудан холбоо, байгууллагад төлөх өглөг нийт 2.9 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;
- Орхон УБХ тайлант онд 2.1 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 96,066.7 сая төгрөг болж, өмнөх оноос 12,855.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо
төгрөгөөр/

/ сая

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|-------------------|--------------------|---------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал | 12,235.0 | 12,230.7 | (4.3) |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 16,115.2 | 16,119.5 | 4.3 |
| Өмч /хувийн/ /ТӨҮГ/ | 15,483.2 | 15,483.2 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 64,577.6 | 51,745.3 | (12,832.2) |
| Өмнөх үеийн үр дүн | 75,568.5 | 62,208.1 | (13,360.4) |
| Тайлант үеийн үр дүн | (10,991.0) | (10,462.8) | 528.2 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 510.8 | 487.9 | (22.9) |
| Дүн | 108,921.7 | 96,066.7 | (12,855.1) |

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо данс буурахад Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолоор Нийслэлийн улсын бүртгэлийн газрыг татан буулгаж, Өмчийн харилцааны газрын 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 1/1438 дугаар албан бичгийг үндэслэн 1188 нэр төрлийн 5615 ширхэг, 6,204.1 сая төгрөгийн хөрөнгө, 111.1 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн бүртгэж, санхүүгийн тайланд хаалтын гүйлгээгээр өмнөх оны хуримтлагдсан үр дүнг бууруулсан нь голлон нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 109,461.7 сая төгрөгөөр төлөвлөж, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцож, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс урсгал зардлыг 14,848.6 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 15,185.8 сая төгрөгөөр тус тус бууруулж, нийт төсвийг 79,427.3 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд анхны баталсан төсвийг 9,764.6 сая төгрөгөөр бууруулан тодотгож, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 69,662.7 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 45,728.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 25,614.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 20,113.6 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-д 17,653.2 сая төгрөгийг шилжүүлж, дараах төлбөртэй лавлагаа, үйлчилгээ болох 1950069 дэлгэрэнгүй, 6398872 энгийн лавлагааг цахимаар үнэ төлбөргүй олгосонтой холбоотой орлого буурсан байна.

Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харахад төлөвлөлийг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй, төлөвлөлт хангалтгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр урсгал зардлыг санхүүжүүлэхээр 69,662.7 сая төгрөгийг улсын төсвөөс авсан байна.

Батлагдсан нийт урсгал зардлын 90.7 хувь буюу 63,178.3 сая төгрөгийг зарцуулж, тайлант оны зарцуулагдаагүй 6,484.4 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|--------------|---|-----------------|-----------------|----------------|-------------|
| 70406 | Улсын бүртгэл, мэдээлэл | 69,662.7 | 63,178.3 | 6,484.4 | 90.6 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 56,426.6 | 50,040.2 | 6,386.4 | 88.6 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 5,718.7 | 5,620.2 | 98.5 | 98.2 |
| 80220 | Холбооны суваг ашигласны хөлс | 629.3 | 629.3 | | 100.0 |
| 80205 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 2.8 | 2.8 | | 100.0 |
| 80303 | Урд оны өр | 3,760.0 | 3,760.0 | - | 100.0 |
| 81503 | Орон нутгийн сонгууль | 210.6 | 210.6 | - | 100.0 |
| 81521 | Иргэний үнэмлэх хэвлэж тараах | 2,915.2 | 2,915.2 | - | 100.0 |
| 80918 | Бусад /хөрөнгө оруулалт | | | | |
| | Төсөвт байгууллагын орлого | 7.4 | 7.4 | - | 100.0 |

/сая төгрөг/

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсвийн санхүүжилт дээд шатны төсөв захирагчаас орон нутгийн нөхөн сонгуулийн 120.2 сая төгрөг, Орон нутгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 143.7 сая төгрөг, Сангийн сайдын 2025 оны 28 дугаар тушаалаар буцаан олгосон 1,062.5 сая төгрөг, Орон нутгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс албан хаагчдад олгох хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэлд 1,676.5 сая төгрөг, нийт 3,002.9 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд 1,457.4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 179.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 14.6 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 104.9 сая төгрөг, дотоод албан томилолт, нормативт зардалд 10.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 25.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 124.8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 10.2 сая төгрөгийг тус тус зарцуулж улсын төсөвт 1,075.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2025 оны А/08 дугаар тушаалаар 29,205.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, 2025 оны 10 дугаар сард төсвийн тодотголоор Хууль зүй дотоод хэргийн сайдын А/105 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-нд нийт 30,434.2 сая төгрөгийн 18 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар баталж, нууцтай холбоотой 2, нээлттэй тендер шалгаруулалт 7, харьцуулалтын худалдан авалт 1, шууд худалдан авалт 8 худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 30,193.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, 99.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн агентлаг, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн агентлагийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, харьяа байгууллагуудын өглөгийг бууруулах, бараа материал, хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүртэл Аудитор Н.Нямсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Ахлах аудитор П.Амарсанаа, Аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/1978 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлын 2024 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 134,807.9 сая төгрөгийн 1.0 хувиар тооцож, 1,348.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 3.5 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлж, зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага, давтан гаргахгүй байх талаар 3.5 сая төгрөгийн 7 зөвлөмж, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК нь үйлдвэрийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн, батлуулахгүйгээр төсвийг зарцуулж, оны эцэст гүйцэтгэлтэй уялдуулан нөхөж батлуулсан;
- Компани засаглалын хувьд төлөвшөөгүй, стратеги төлөвлөгөө байхгүйгээс Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг оны эцэст буюу 12 дугаар сард хийж, тайлант онд төлөвлөгөөгүй ажилласан, Үйлдвэрийн зарим үйл ажиллагаа түр зогссон, ашигт ажиллагаа буурсан нь цаашид компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж, үйлдвэрлэл тасалдах, Монгол Улсын ирээдүйн зорчих эрхэд сөрөг нөлөө үүсэх эрсдэлтэй.

4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага болон дээд шатны төсвийн захирагчаас төрийн хэмнэлттэй холбоотой тушаал, шийдвэр гарах, арга хэмжээ авах нөхцөл байдал үүсээгүй, 2025 оны баталсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулсан байна.

4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт:

- Дундговь аймгийн УБХ Шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 7 шийдвэрийг мэдээлээгүй;
- Өмнөговь аймгийн УБХ шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5 гүйлгээ, орлогын 12 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн;
- Сэлэнгэ аймгийн УБХ шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн;
- Төв аймгийн УБХ шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 100.6%, хугацаа хоцролт 81.6% буюу 40 мэдээлэл хугацаа хоцроосон;
- Булган аймгийн УБХ 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн;
- Орхон аймгийн УБХ шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 428.6 сая төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй;
- Хөвсгөл аймгийн УБХ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд нийтлээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4 Судалгааны үр дүн

Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд судалгаа авч нэгтгэн дүгнэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээнд УБЕГ-ын 2024 оны А/164 дугаар тушаалаар 1263 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр газар хэлтсийг цөөлөх замаар удирдах ажилтны тоог цөөрүүлж, албан хаагчдын орон тоог хэвээр үлдээсэн.
- Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлыг УБЕГ-ын даргын 2024 оны А/164 дүгээр тушаалаар 1 өдөрт хоол /23.0 мянган/ төгрөг, унаа /1.0 мянган/ төгрөг байхаар баталсан байна. Төлөвлөгөөнд нийт 6,109.0 сая төгрөгөөр баталж, 7,188.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй.
- Гадаад томилолтын 1 арга хэмжээнд 39.0 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр гадаад паспортын бэлдэц худалдан авах гэрээтэй холбоотой Бүгд найрамдах Унгар улсад ажилласан.
- Тайлант онд сургалт, семинарын зардалд 115.8 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 96.3 сая төгрөг зарцуулсан бөгөөд хурал, зөвлөгөөн, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөр, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төвлөрүүлэн захирагчид өгсөн 27,906.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 43.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 27,816.3 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага хүргүүлж, 46.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 18 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|-----------|-----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 43.5 | 2 | 43.5 | 100.0 |
| Албан шаардлага | 24 | 27,816.3 | 24 | 27,816.3 | 100.0 |
| Зөвлөмж | 18 | 46.8 | 18 | 46.8 | 100.0 |
| Дүн | 10 | 27,906.6 | 10 | 27,906.6 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг шалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК -ийн 51.0 хувийн хувьцаа эзэмшигч буюу төрийн төлөөлөл болох Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зүгээс ТУЗ болон гүйцэтгэх захиралд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт;
- Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн үйлдвэрлэж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүлээлгэн өгсөн гадаад паспортын тоо ширхгийг статистик мэдээ, орлоготой уялдуулан тулган баталгаажуулах;
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн цалин орон тооны асуудал.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 23 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 16 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 7 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан 16 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 15, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 2,895.8 сая төгрөгийн 52 алдаа, зөрчлийг илрүүлж, аудитын явцад 300.4 сая төгрөгийн 15 алдааг залруулж, 17.3 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 2,031.7 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага хүргүүлж, 546.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 19 зөвлөмж өгч, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,595.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,247.2 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Үүнээс: Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 2,595.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 17.3 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 2,031.6 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага хүргүүлж, 546.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 19 зөвлөмж өгч, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа газруудын зөрчилтэй холбоотой.

Илрүүлэлт 1. Харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 2,595.3 сая төгрөгийн 37 зөрчил илэрснээс 17.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 2,031.7 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага хүргүүлж, 546.4 сая төгрөгийн зөрчилд 19 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 1 албан шаардлага өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын төсвийн шууд захирагчийн асуудал:

1. Цахим гадаад паспортын бэлдэцтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Унгарын Мөнгөн тэмдэгт хэвлэл ХК-тай хийсэн “Хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу хүлээн авах гадаад паспортын хэвлэлийн алдаатай бэлдцийг устгах

ажлыг эцэслэн шийдвэрлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайланд ашиглалтгүй бараа материал, авлага бүртгэлтэй хэвээр байна.

Энэ нь Иргэний хуулийн 193 дугаар зүйлийн 193.1-т “Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг гэрээний аль нэг тал буюу гуравдагч этгээд тодорхойлсон нь нөгөө талд буюу талуудад эргэлзээ төрүүлэхээр бол шударга ёсны зарчимд нийцүүлэн харилцан хүсэл зоригоо илэрхийлэх замаар шийдвэрлэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, “Хамтын ажиллагааны гэрээ”-ний заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Унгарын Мөнгөн тэмдэгт хэвлэл ХК-аас гэрээний дагуу хүлээн авах гадаад паспортын хэвлэлийн алдаатай бэлдцийг устгах ажлыг эцэслэн шийдвэрлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 178.7 сая төгрөгийн бичиг хэргийн материал авахаар төлөвлөж, Алтанзуун ХХК, Төгсдардас ХХК-тай гэрээ байгуулахдаа гэрээний хугацааг он дамжуулан хийж, гүйцэтгэлээр 75.8 сая төгрөгийг шилжүүлсэн нь гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх боломжгүй болгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5.2.4-т “Цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 41.2.4-т “Төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах, 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн жил дамжуулан гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх боломжгүй болгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт 1. Хүрээ Плас ХХК-тай "Astory event hall-д заал түрээслэх" 10.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, удирдах албан тушаалтны зөвлөгөөн хийж, тус компанид 2.0 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 8.3 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр иргэний дансанд шилжүүлсэн байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, төсвийг үр ашигтай удирдлагаар хангаж, ажиллах.

Илрүүлэлт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 37.6 сая төгрөгийн 2850 ширхэг гэрчилгээ, 19.9 сая төгрөгийн 19900 ширхэг гарын авлага, 19.5 сая төгрөгийн 1000 ширхэг хуулийн товхимол, 12.1 сая төгрөгийн 2700 ширхэг дэвтэр, 20.0 сая төгрөгийн 1500 ширхэг журмын эмхэтгэл, 19.8 сая төгрөгийн 100 ширхэг НБББББ, 18.7 сая төгрөгийн 580 ширхэг текст, лого металл хэвлэл, 73.2 сая төгрөгийн 1800 ширхэг үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, нийт 166.2 сая төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг Үндэсний үнэт цаас ХХК-иас худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 22 дугаар зүйл 22.6-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ: 22.6.3-т "Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх", 22.6.6-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангилал бүрээр, дэлгэрэнгүй бэлтгэж, батлагдсан төсөвт багтаан зарцуулах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх.

Илрүүлэлт 3. Лицензийн төлбөрийг урьдчилж гарсан зардал дансаар дамжуулан бүртгэж, сар бүр тохируулах бичилт хийж, зардалд хуваарилаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ" 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанд гарган ҮАГ-т ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|------------------------|------------|------------------|--------------------------|----------|------------|------------------|--------------|----------|----------|----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Говьсүмбэр аймгийн УБХ | 1 | 242.3 | | | 1 | 242.3 | | | | |
| | 1 | 42,723.6 | | | 1 | 42,723.6 | | | | |
| Дархан-Уул аймгийн УБХ | 1 | 522.7 | | | 1 | 522.7 | | | | |
| | 1 | 704.0 | | | 1 | 704.0 | | | | |
| | 1 | 23,520.0 | | | 1 | 23,520.0 | | | | |
| | 1 | 2,248.5 | | | 1 | 2,248.5 | | | | |
| Орхон аймгийн УБХ | 1 | 162,115.2 | | | 1 | 162,115.2 | | | | |
| | 1 | 240.0 | | | 1 | 240.0 | | | | |
| Өвөрхангай аймгийн УБХ | 1 | 249.5 | | | 1 | 249.5 | | | | |
| Сэлэнгэ аймгийн УБХ | 1 | 310.6 | | | 1 | 310.6 | | | | |
| Төв аймгийн УБХ | 1 | 584.5 | | | 1 | 584.5 | | | | |
| | 1 | 210.7 | | | 1 | 210.7 | | | | |
| Ховд аймгийн УБХ | 1 | 2,429.2 | | | 1 | 2,429.2 | | | | |
| Увс аймгийн УБХ | 1 | 62,970.2 | | | 1 | 62,970.2 | | | | |
| Хэнтий аймгийн УБХ | 1 | 1,372.7 | | | 1 | 1,372.7 | | | | |
| НИЙТ | 15 | 300,443.7 | - | - | 15 | 300,443.7 | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Зөрчлийн товч утга | Нийт | | Акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | |
|---|------------------|--|------|---------|-----|---------|-----------------|-----|---------|-----|-----------------------------------|-----|
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | УБЕГ ТТЗ | Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 2,595.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 17.3 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 2,031.6 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага хүргүүлж, 546.4 сая төгрөгийн зөрчилд 19 зөвлөмж өгч, хариуцлага тооцох 1 албан шаардлага өгсөн байна. өгсөн нь харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна. | 1 | - | | | 1 | | | | | |
| 2 | Дархан-Уул УБХ | Тайлант онд хэлтсийн даргын Б/04 тоот тушаалаар ерөнхий нягтлан бодогч Ц.Оюунбилэгт сахилгын шийтгэл ногдуулсан байхад балансын урамшуулал 1.6 сая төгрөг олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. | 1 | 1,559.0 | 1 | 1,559.0 | | | | | | |
| 3 | Дундговь УБХ | Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон. | 1 | 7,885.0 | 1 | 7,885.0 | | | | | | |
| 4 | Дундговь УБХ | Нягтлан бодогчийг хэлтсийн нягтлан бодох бүртгэлийг хариуцлагатай гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсан гэж 2 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн шагналыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон. | 1 | 3,304.0 | 1 | 3,304.0 | | | | | | |
| 5 | Сүхбаатар УБХ | Амрах тухай тушаал гарсан боловч амралтыг бодитоор эдлээгүй, удирдлагын шийдвэргүйгээр нягтлан бодогч нь 2024, 2025 онуудад өөрийн ээлжийн амралтыг урьдчилан тооцож амралтын мөнгийг авсан байтал тухайн хугацаанд цалинг үргэлжлүүлэн тооцож давхардуулсан байна. Мөн орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 4 дүгээр сард 30 хувь авах байсныг 60 хувиар тооцож, нийт 4.5 сая төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 4,543.1 | 1 | 4,543.1 | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|----|-------------------|--|---|----------|--|--|---|----------|--|---|---|
| 6 | Архангай УБХ | Тайлант онд 18 албан хаагчид олгосон 4.8 сая төгрөгийн цалин хөлс болон нэмэгдэл, урамшуулалд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж тайлагнаагүй байна. | 1 | 4,848.3 | | | 1 | 4,848.3 | | | |
| 7 | Баянхонгор УБХ | Байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй газар нь үндсэн хөрөнгийн бүртгэлд 572 мкв талбайтай бүртгэгдсэн байхад газрын эзэмших гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn) -нд 1762 мкв -аар бүртгэлтэй буюу 1190 мкв -аар зөрүүтэй бүртгэсэн байна. | 1 | - | | | 1 | - | | | |
| 8 | Дундговь УБХ | Нягтлан бодогч Х.Гарам өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актын зөрчлийг гаргаж, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ. | 1 | - | | | | - | | 1 | - |
| 9 | Орхон УБХ | Байгууллагын шатах, тослох материалын тайланд жолоочийн жолооны тооцооны хуудсыг хянаж, нэгтгэн тооцоо бодохгүйгээр 1.2 сая төгрөгийн зардлыг бүртгэлд тусгасан байна. | 1 | 1,188.4 | | | 1 | 1,188.4 | | | |
| 10 | Орхон УБХ | Улсын бүртгэлийн ерөнхий газраас хэлтсийн даргад эхний хагас жилийн үнэлгээгээр 50, сүүлийн хагас жилийн үнэлгээгээр 75 хувийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн байтал аймгийн Засаг даргын захирамжийг үндэслэн 75 хувийн урамшууллыг нэмж, 1.5 сая төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 1,536.8 | | | 1 | 1,536.8 | | | |
| 11 | Орхон УБХ | Албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд олгосон санхүүжилтээс 4.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. | 1 | 4,422.9 | | | 1 | 4,422.9 | | | |
| 12 | Хэнтий УБХ | Тайлант онд нэр бүхий 20 ажилтанд 16.9 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг архивын улсын үзлэгт бэлдэх нэрээр олгосон байна. | 1 | 16,930.4 | | | 1 | 16,930.4 | | | |
| 13 | ТҮЦХ ТӨОХХК | Тайлант онд Мүүрь аудит ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр МА-2025-ЗҮ-01 дугаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулж, 9.0 сая төгрөгийн урьдчилгаа төлсөн боловч гүйцэтгэл хангалтгүй, компанийн үйл ажиллагаанд тохирсон дансны харьцаа, бүртгэл, хөрөнгийн элэгдэл тооцох аргачлал тусгаагүй, захиалагчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй байна. | 1 | 9,000.0 | | | 1 | 9,000.0 | | | |
| 14 | ТҮЦХ ТӨОХХК | 1. Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлахгүйгээр нийт 36.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй; | 1 | 59,407.5 | | | 1 | 59,407.5 | | | |

| | | | | | | | | | | | |
|----|---|--|---|-------------|--|--|---|-------------|---|---------|--|
| | | 2. Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, гэрээ байгуулахгүйгээр Шунхлай ХХК-аас 23.2 сая төгрөгийн шатахууныг худалдан авсан. | | | | | | | | | |
| 15 | ТҮЦХ ТӨОХХК | 1. Тайлант онд цахим гадаад паспорт үйлдвэрлэхэд ашигладаг 137200 ширхэг поликарбонатыг 5,363.3 сая төгрөгөөр худалдан авсан байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад түүхий эдийн чанараас шалтгаалан жилийн эцсийн байдлаар 78.2 сая төгрөгийн өртөгтэй 1302 ширхэг цахим паспорт чанарын шаардлага хангахгүй хэвлэгдэж, хорогдол үүссэн; 2. Компанийн хэмжээнд 2023-2025 онд нийт 15711 ширхэг, 1,351.1 сая төгрөгийн үнэтэй поликарбонат гологдол үүсгэсэн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд орохоос өмнө чанарын шаардлага хангахгүй, түүхий эд нийлүүлэгдсэн нь балансын болон үйлдвэрлэлийн ашигт ажиллагааны нөлөөлж алдагдал хүлээж, болзошгүй байна. | 1 | 1,429,397.5 | | | 1 | 1,429,397.5 | | | |
| 16 | ТҮЦХ ТӨОХХК | Тайлант онд Мигасон ХХК-тай байгуулсан 403.3 сая төгрөгийн, Монгол даатгал ХХК-тай байгуулсан 17.9 сая төгрөгийн, Чэк мэйт ХХК-тай байгуулсан 8.2 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна. | 1 | 429,150.0 | | | 1 | 429,150.0 | | | |
| 17 | Улсын бүртгэлийн н ерөнхий газар аппрат | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 178.7 сая төгрөгийн бичиг хэргийн материал авахаар төлөвлөж, Алтанзуун ХХК, Төгсдардас ХХК-тай гэрээ байгуулахдаа гэрээний хугацааг он дамжуулан хийж, гүйцэтгэлээр 75.8 сая төгрөгийг шилжүүлсэн нь гэрээ дүгнэж, гүйцэтгэлд хяналт тавих боломжгүй байна. | 1 | 75,782.6 | | | 1 | 75,782.6 | | | |
| 18 | Улсын бүртгэлийн н ерөнхий газар аппрат | Унгарын Мөнгөн тэмдэгт хэвлэл ХК-тай хийсэн "Хамтын ажиллагааны гэрээ"-ний дагуу хүлээн авах гадаад паспортын хэвлэлийн алдаатай бэлдцийг устгах ажлыг эцэслэн шийдвэрлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайланд ашиглалтгүй бараа материал, авлага бүртгэлтэй хэвээр байна | 1 | - | | | 1 | - | | | |
| 19 | Булган УБХ | Шатахууны зарцуулалтын тайланг 6, 10, 11 саруудын 2.3 сая төгрөгийн нярвын тайланг сар | 1 | 2,300.0 | | | | | 1 | 2,300.0 | |

| | | | | | | | | | | | |
|----|--------------|---|---|-----------|--|--|--|---|-----------|--|--|
| | | тус бүрээр бүрэн гаргаж баримтжуулан ажиллаагүй. | | | | | | | | | |
| 20 | Орхон УБХ | Тайлант онд 2.1 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. | 1 | 2,050.9 | | | | 1 | 2,050.9 | | |
| 21 | Орхон УБХ | Батлагдсан төсвөөс 2.5 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан. | 1 | 2,527.1 | | | | 1 | 2,527.1 | | |
| 22 | Орхон УБХ | Байгууллагын 2025 оны санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй. | 1 | - | | | | 1 | - | | |
| 23 | Өмнөговь УБХ | Санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын 2-р хавсралт "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгээгүй байна. | 1 | - | | | | 1 | - | | |
| 24 | Сэлэнгэ УБХ | Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 172.8 сая төгрөгийн анхны үнэтэй 80 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна. | 1 | 172,833.7 | | | | 1 | 172,833.7 | | |
| 25 | Сэлэнгэ УБХ | Хөрөнгийн элэгдлийг илүү болон дутуу тооцсон. | 1 | 7,145.2 | | | | 1 | 7,145.2 | | |
| 26 | Төв УБХ | Тайлант онд шуудан холбооны өглөг 0.5 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 2.5 сая төгрөг, нийт 2.9 сая төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн байна. | 1 | 2,931.2 | | | | 1 | 2,931.2 | | |
| 27 | Ховд УБХ | Зардлын зүйл анги зөрчсөн. Тухайлбал хөдөлмөр хамгааллын зардлаас үндсэн хөрөнгө, бараа материалын шинжтэй хөрөнгө, тээврийн хөлс зэрэгт 0.3 сая төгрөгийн, мэдээлэл технологийн зардлаас тээврийн хөлс 0.8 сая төгрөг, урсгал засварын зардлаас бараа материал, хог хаягдлын зардалд 0.2 сая төгрөг, нийт 1.3 сая төгрөгийн зардлын зүйл анги зөрчсөн. | 1 | 1,330.5 | | | | 1 | 1,330.5 | | |
| 28 | Ховд УБХ | 2022 оны 01 сарын 06-ны өдрийн аймгийн Засаг даргын А/25 тоот захирамжтай 8414009055 нэгж талбарын дугаартай, 0000064759 дугаартай, Э-1617001055 эрхийн бүртгэлийн дугаартай байгууллагын эзэмшлийн 3000 кв газрыг данс бүртгэлд бүртгээгүй. | 1 | 13,500.0 | | | | 1 | 13,500.0 | | |
| 29 | Хөвсгөл УБХ | Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны худалдан авах ажиллагааны | 1 | - | | | | 1 | - | | |

| | | | | | | | | | | | |
|----|---------------|--|---|----------|--|--|--|---|----------|--|--|
| | | төлөвлөгөөг tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээгүй байна. | | | | | | | | | |
| 30 | Сүхбаатар УБХ | Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа боловч дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | | | | 1 | - | | |
| 31 | ТҮЦХ ТӨОХХК | Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн дүрмийн сан 31,598.4 сая төгрөг байгаагаас 51 хувь эзэмшигчийн оруулсан хөрөнгө 16,115.2 сая төгрөг, 49 хувь эзэмшигчийн оруулсан хөрөнгө 15,483.2 сая төгрөгийг талууд тус тус хувь нийлүүлэн үйл ажиллагаа явуулж байна. Харин дээрх хуулийн этгээд цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, компанийн засаглалын кодексийг бий болгох, санхүү, эдийн засгийн харилцаанд ороход хувь нийлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохгүй байгаа нь хувь эзэмшлийн маргаан үүсэх, ашигт ажиллагаа буурах, үндсэн үйл ажиллагаа доголдох зэрэг сөрөг нөлөө үзүүлэхээр байна. | 1 | - | | | | 1 | - | | |
| 32 | ТҮЦХ ТӨОХХК | Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 25/03 дугаар тогтоолоор бүтэц орон тооны дээд хязгаарыг 50 ажилтантай байхаар баталсан боловч НД-ын 12 дугаар сарын тайланд үндсэн 51 ажилтан, жирэмсэн, тэтгэвэрт гарсан 5, нийт 65 албан хаагчаар тайлагнасан. Мөн зорилтот түвшинг 49.4 сая төгрөгөөр хэтрүүлж, 1,981.4 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан. | 1 | 49,415.9 | | | | 1 | 49,415.9 | | |
| 33 | ТҮЦХ ТӨОХХК | Ажил, гүйлгээ гарсныг нотлох, гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт, бусад нотолгоо буюу анхан шатны 98.6 сая төгрөгийн баримтыг үнэн, зөв, иж бүрэн бүрдүүлж, ажиллаагүй байна. | 1 | 98,588.2 | | | | 1 | 98,588.2 | | |
| 34 | ТҮЦХ ТӨОХХК | Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа явуулдаг Даймонд программын үндсэн эх код, эзэмшигч нь тус үйлдвэрийн хувьцаа эзэмшигч Мигасон ХХК байгаа нь санхүү, төсвийн үйл ажиллагаа хараат бусаар хэрэгжих, хөгжүүлэлт хийх, нууцлалын шаардлага хангахгүй байна. | 1 | - | | | | 1 | - | | |
| 35 | УБЕГ аппарат | Хүрээ Плас ХХК-тай "Astory event hall-д заал түрээслэх" 10.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, | 1 | 8,320.0 | | | | 1 | 8,320.0 | | |

| | | | | | | | | | | | | |
|-------------|----------------|--|-----------|--------------------|----------|-----------------|-----------|--------------------|-----------|------------------|----------|----------|
| | | удирдах албан тушаалтны зөвлөгөөн хийж, тус компанид 2.0 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 8.3 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр иргэний дансанд шилжүүлсэн байна. | | | | | | | | | | |
| 36 | УБЕГ аппрат | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 37.6 сая төгрөгийн 2850 ширхэг гэрчилгээ, 20.0 сая төгрөгийн 19900 ширхэг гарын авлага, 19.5 сая төгрөгийн 1000 ширхэг хуулийн товхимол, 12.1 сая төгрөгийн 2700 ширхэг дэвтэр, 20.0 сая төгрөгийн 1500 ширхэг журмын эмхэтгэл, 19.8 сая төгрөгийн 100 ширхэг НБББББ, 18.7 сая төгрөгийн 580 ширхэг текст, лого металл хэвлэл, 73.2 сая төгрөгийн 1800 ширхэг ҮХЭХ-ийн гэрчилгээ зэрэг тусгай зориулалтын бараа материалыг Үндэсний үнэт цаас ХХК-иас худалдан авсан байна. | 1 | 166,230.0 | | | | | 1 | 166,230.0 | | |
| 37 | УБЕГ аппрат | Лицензийн төлбөрийг урьдчилж гарсан зардал дансаар дамжуулан бүртгэж, сар бүр тохируулах бичилт хийж, зардалд хуваарилаагүй байна. | 1 | 19,200.0 | | | | | 1 | 19,200.0 | | |
| НИИТ | | | 37 | 2,595,328.0 | 4 | 17,291.1 | 13 | 2,031,664.2 | 19 | 546,372.7 | 1 | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Зөрчлийн товч утга | Нийт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
|--|----------------------|--|----------|----------------|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|---------------|
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал | | | | | | | | | | |
| 1 | Дундговь аймгийн УБХ | Шилэн дансны цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 7 шийдвэрийг мэдээлээгүй. | 1 | 3,499.1 | | | 1 | 3,499.1 | | |
| 2 | Өмнөговь аймгийн УБХ | Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын /төвлөрүүлэх шилжүүлэг/ 5 гүйлгээ, орлогын 12 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | | | 1 | - | | |
| 3 | Сэлэнгэ аймгийн УБХ | Шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | - | | | 1 | - | | |
| 4 | Төв аймгийн УБХ | Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 100%, хугацаа хоцролт 81.6% буюу 40 мэдээлэл хугацаа хоцроосон байна. | 1 | - | | | 1 | - | | |
| 5 | Булган аймгийн УБХ | 4 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | - | | | 1 | - | | |
| 6 | Орхон аймгийн УБХ | Шилэн дансны цахим хуудсанд 171 мэдээлэл оруулахаас 5 сая төгрөгөөс дээш орлогын 428.6 сая төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй. | 1 | - | | | 1 | - | | |
| 7 | Хөвсгөл аймгийн УБХ | Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нийтлээгүй байна. | 1 | - | | | 1 | - | | |
| | | | 7 | 3,499.1 | - | - | 7 | 3,499.1 | - | - |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал | | | | | | | | | | |
| 8 | ТҮЦХ ТӨОХХК | Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК нь үйлдвэрийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулахгүйгээр төсвийг зарцуулж, оны эцэст гүйцэтгэлтэй уялдуулан нөхөж батлуулсан; | 1 | - | | | | | 1 | - |

| | | | | | | | | | | |
|----------------------|----------------|---|----------|----------------|----------|----------|----------|----------|----------|----------|
| 9 | ТҮЦХ ТӨОХХК | Компани засаглалын хувьд төлөвшөөгүй, стратеги төлөвлөгөө байхгүйгээс Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг оны эцэст буюу 12 дугаар сард хийж, тайлант онд төлөвлөгөөгүй ажилласан; 2. Үйлдвэрийн зарим үйл ажиллагаа түр зогссон, ашигт ажиллагаа буурсан нь цаашид компанийн хэвийн үйл ажиллагаанд эрсдэл учруулж, үйлдвэрлэл тасалдах, Монгол Улсын иргэдийн зорчих эрхэд сөрөг нөлөө үүсэх эрсдэлтэй байна. | 1 | - | 1 | - | | | | |
| НИЙТ | | | 2 | - | 1 | - | | | 1 | - |
| НИЙЦЛИЙН БҮГД | | | 9 | 3,499.1 | 1 | - | 7 | - | 1 | - |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1076/А0170083

Улаанбаатар хот

САГ-2026/13/НА - СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын нэгжийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс харьяа 23 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,595,327,980.46 /Хоёр тэрбум таван зуун ерэн таван сая гурван зуун хорин долоон мянга есөн зуун наян төгрөг дөчин зургаан мөнгө/-ний зөрчил илэрснээс 17,291,065.00 /Арван долоон сая хоёр зуун ерэн нэгэн мянга жаран таван/ төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 2,031,664,204.00 /Хоёр тэрбум гучин нэгэн сая зургаан зуун жаран дөрвөн мянга хоёр зуун дөрвөн/ төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага хүргүүлж, 546,372,711.46 /Таван зуун дөчин зургаан сая гурван зуун далан хоёр мянга долоон зуун арван нэгэн төгрөг дөчин зургаан мөнгө/-ний зөрчилд 19 зөвлөмж өгч, 1 хариуцлага тооцох албан шаардлага өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264130

Z:\Alban.Shaardlaga\2026\0325 SAG-4.Docx

1526181310

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга (Д.Давааням), Санхүү, үйлчилгээний хэлтсийн дарга (С.Энхнаран), Дотоод аудит хариуцсан мэргэжилтэн (Н.Уртнасан) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1077/АД170083

Улаанбаатар хот

САГ-2026/13/НА - СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Унгарын Мөнгөн тэмдэгт хэвлэл ХК-тай хийсэн “Хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу хүлээн авах гадаад паспортын хэвлэлийн алдаатай бэлдцийг устгах ажлыг эцэслэн шийдвэрлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайланд ашиглалтгүй бараа материал, авлага бүртгэлтэй хэвээр байна.

Иргэний хуулийн 193 дугаар зүйлийн 193.1-т “Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг гэрээний аль нэг тал буюу гуравдагч этгээд тодорхойлсон нь нөгөө талд буюу талуудад эргэлзээ төрүүлэхээр бол шударга ёсны зарчимд нийцүүлэн харилцан хүсэл зоригоо илэрхийлэх замаар шийдвэрлэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Унгарын Мөнгөн тэмдэгт хэвлэл ХК-аас гэрээний дагуу хүлээн авах гадаад паспортын хэвлэлийн алдаатай бэлдцийг устгах ажлыг эцэслэн шийдвэрлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга (Д.Давааням), Санхүү, үйлчилгээний хэлтсийн дарга (С.Энхнаран) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 7-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\Alban Sheardlaga\2026\0325 SAG-4.Docx

1526181312



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1078/А0170083

Улаанбаатар хот

САГ - 2026/13/НА - СТА - ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 178,734,500.00 /Нэг зуун далан найман сая долоон зуун гучин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн бичиг хэргийн материал авахаар төлөвлөж, Алтанзуун ХХК, Төгсдардас ХХК-тай гэрээ байгуулахдаа гэрээний хугацааг он дамжуулан хийж, гүйцэтгэлээр 75,782,550.00 /Далан таван сая долоон зуун наян хоёр мянга таван зуун тавин/ төгрөгийг шилжүүлсэн нь гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх боломжгүй болгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5.2.4-т "Цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 41.2.4-т "Төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах, 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн жил дамжуулан гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх боломжгүй болгосон зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга (Д.Давааням), Санхүү, үйлчилгээний хэлтсийн дарга (С.Энхнаран) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
П.АМАРСАНАА
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-4.Docx

1526191314